



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани болон "Автотээврийн үндэсний төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 190,057,383.57 (нэг зуун ерэн сая тавин долоон мянга гурван зуун наян гурван төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 70,404,390.84 (далан сая дөрвөн зуун дөрвөн мянга гурван зуун ерэн төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газар, "Автотээврийн үндэсний төв" улсын төсөвт үйлдвэрийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Баянхонгор аймаг дахь газарт балансаас балансад тус тус шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэбаяр, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн захирал Б.Нямсамбуу болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

АХРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000653

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн  
344 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР, "ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК,  
"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" УТУГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД,  
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Автомашинны нэр, марк, улсын бүртгэлийн дугаар, арлын дугаар | Ашиглалтад орсон огноо | Балансын нийт үнэ (төгрөг)                                                                                 | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                                                                  | Үлдэгдэл өртөг (төгрөг)                                                                                                 | Шилжүүлэх хуулийн этгээд                   | Шилжүүлэн авах хуулийн этгээд                                   |
|-----|--------------------------------------------------------------|------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| 1   | Хьюндай соната lf, 05-56 УБҮ (арал-кмhe241cbka504476)        | 2018.12.17             | 73,980,000.00                                                                                              | 7,192,500.00                                                                                    | 66,787,500.00                                                                                                           | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Засгийн газрын автобааз ТӨҮГ                                    |
|     | Дүн                                                          |                        | 73,980,000.00                                                                                              | 7,192,500.00                                                                                    | 66,787,500.00                                                                                                           |                                            |                                                                 |
| 2   | Хьюндай соната-7, 22-36 УНВ (арал-кмheс41mbaa072887)         | 2013.08.31             | 24,000,000.00                                                                                              | 14,395,618.47                                                                                   | 9,604,381.53                                                                                                            | "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК | "Автотээврийн үндэсний төв" УТУГ                                |
|     | Дүн                                                          |                        | 24,000,000.00                                                                                              | 14,395,618.47                                                                                   | 9,604,381.53                                                                                                            |                                            |                                                                 |
| 3   | Ниссан тийна, 01-43 УБЗ (арал 1n4a13ap4gc188609)             | 2017.12.28             | 59,900,000.00                                                                                              | 16,638,888.80                                                                                   | 43,261,111.20                                                                                                           | "Автотээврийн үндэсний төв" УТУГ           | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар                      |
|     | Дүн                                                          |                        | 59,900,000.00                                                                                              | 16,638,888.80                                                                                   | 43,261,111.20                                                                                                           |                                            |                                                                 |
| 4   | Ниссан экстрэйл, 18-42 УБӨ (арал jn1bnt30z0115302)           | 2007.01.01             | 32,177,383.57                                                                                              | 32,177,383.57                                                                                   | -                                                                                                                       | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Баянхонгор аймаг дахь газар |
|     | Дүн                                                          |                        | 32,177,383.57                                                                                              | 32,177,383.57                                                                                   | -                                                                                                                       |                                            |                                                                 |
|     | Нийт дүн                                                     |                        | 190,057,383.57<br>(нэг зуун ерэн сая тавин долоон мянга гурван зуун наян гурван төгрөг тавин долоон мөнгө) | 70,404,390.84<br>(далан сая дөрвөн зуун дөрвөн мянга гурван зуун ерэн төгрөг наян дөрвөн мөнгө) | 119,652,992.73<br>(нэг зуун арван есөн сая зургаан зуун тавин хоёр мянга есөн зуун ерэн хоёр төгрөг далан гурван мөнгө) |                                            |                                                                 |